



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2025.04.28 № 9/907
танай _____-ны № _____-т

ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ш.МӨНХХУЯГ ТАНАА

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2025 оны 4 дүгээр сарын 07-оос 2025 оны 4 дүгээр сарын 12-ны хооронд сумдад ажиллаж бодлогын баримт бичгийн төлөвлөлт, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулан дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын батлуулсан Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан боловч төлөвлөлт болон хоорондын уялдаа хангалтгүй байна. Жишээ нь: аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс сумдад хамааралтай арга хэмжээг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд бүрэн тусгаагүй, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 онд хэрэгжүүлэх зорилт арга хэмжээнээс орхигдуулсан, ихэнх заалт арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг оновчгүй тодорхойлсон байна.

Нийгмийн бодлогын мэргэжилтэн М.Эрдэнэбулган, хөдөө аж ахуйн тасгийн дарга Ч.Бат-Эрдэнэ, мэргэжилтэн Д.Батзориг, Д.Сүнжидмаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Азжаргал, санхүү албаны дарга Д.Агаармандал зэрэг төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг шалгахад байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс шууд хуулж тавьсан, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хэрэгжих хугацааг оновчгүй алдаатай төлөвлөсөн. Харин төрийн чиг үүргийн төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээний өөрт хамраалтай заалтуудыг гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгасан давуу тал ажиглагдсан.

Сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог жил бүр шинэчлэн баталдаг. 2025 онд сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог баталсан шийдвэр 2 удаа гаргасан. Төсвийн шууд захирагч болон төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тооны захиалгыг томилох эрх бүхий албан тушаалтан мэдээллээ Салбар зөвлөлд хүргүүлж хэвшсэн. Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрөл авахаар Төрийн

231060213

албаны зөвлөлд саналаа хүргүүлээгүй, Батлагдсан албан тушаалын тодорхойлолтгүй албан тушаалд төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэн А.Азжаргалыг түр томилсон. Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Дамдинпүрэвийг Биндэр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлаар сэлгэн ажиллуулахаар томилсон. Сургуулийн менежер Д.Эрдэнэтуяаг 2025.04.01-ний өдрөөс түр орлон гүйцэтгэгчээр томилсон. Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Б.Одмаа нь суралцахаар түр чөлөөлөгдсөн тул 2023.10.01-ний өдрөөс М.Мөнхчимэгийг эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон. Төрийн жинхэнэ албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлт нь зарим албан хаагчийн төрийн албаны нөөцөд бүртгэгдсэнийг нотлох, төрийн албаны шалгалт өгсөн, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн тогтоол зэрэг баримт бичиг дутуу байна. Хүний нөөцийн шийдвэр гаргах, хувийн хэргийн бүрдүүлэлт зэрэг анхаарах зүйлсийн талаар арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

Зөвлөмж: Бодлогын баримт бичгийн төлөвлөлт

1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дахин засварлаж төлөвлөхдөө сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт тус бүрийг арга хэмжээ болгон задлан шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг тоо болон чанараар илэрхийлэн оновчтой тодорхойлох

2.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан сумдад хамааралтай заалт арга хэмжээг бүрэн тусгах

3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар төлөвлөх (сумын Соёлын төв анхаарах)

4.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухайн оны хэрэгжүүлэх заалт арга хэмжээг бүрэн тусгах

5.Аймгийн Засаг даргын 2022 оны А/289 захирамжийн хавсралтын дагуу тайлангуудыг заасан хугацаанд тайлагнах, үүнийг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эзэнжүүлэн тусгах

6.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалт, арга хэмжээний жагсаалт гарган эзэнжүүлж, байгууллагын даргаар баталгаажуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах тухай байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах

7.Сумын Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сумын төсөвт байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай тусгах

8.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар төлөвлөх

9.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулан өөрт хамааралтай арга хэмжээ болгоныг гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө зорилт болгож аваад нарийвчлан задалж боловсруулах, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт, чиг үүргийг тусгах

10.Бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө шалгуур үзүүлэлтэд тавигдах шаардлагын дагуу шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг нарийвчлан оновчтой тодорхойлох

11.Үг үсгийн алдаагүй төлөвлөх

Захирамж, тушаал болон эрх зүйн хөтчийн булангийн талаар

12.Хэнтий.мн сайтад 2025 оны захирамж, тушаалуудыг оруулах,

13.Хууль тогтоомжийн хүчинтэй эсэхийг хянаж, зүйл заалтуудыг зөв, гүйцэд оруулах дээр анхаарах,

14.Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын (2024 оны 214 дүгээр тогтоол) хэрэгжилтийг хангаж ажиллах.

15.Эрх зүйн хөтчийн буланг ажиллуулж байгаа сум

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс хийсэн хяналт, шалгалт

16. Бүтэц, орон тооны шийдвэрийг жил бүр батлахгүй байх. Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Засгийн газрын тогтоолын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан орон тооны хязгаарт багтааж ажиллуулах ба чиг үүрэг бүтэц, хүн амын тоо өөрчлөгдсөн тохиолдолд Засгийн газрын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэж орон тооны хязгаарт багтааж бүтэц, орон тоо баталсан шийдвэрийг дахин өөрчилнө.

17. Албан хаагчдыг цаашид тогтвор суурьшилтай ажиллуулахад сэдэлжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах

18. Төрийн албаны тухай хуулийн 42, 43 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг баримтлан тухайн байгууллагын албан хаагчаар албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх

19. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтийг хангах

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

А.ЖАРГАЛСАЙХАН

